


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/01

Мандалговь

┌ Албан тушаалын цалин, нэмэгдлийг
шинэчлэн тогтоох тухай ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.2, 57.2.4, Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.10, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2, 5 дугаар хавсралт, 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоол, 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоолын 4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/17, А/18 дугаар захирамжуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын албан хаагчдын албан тушаалын үндсэн цалин, нэмэгдлийг хавсралтын дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Албан хаагчдын албан тушаалын үндсэн цалин, нэмэгдлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр тооцож олгохыг нягтлан бодогч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЦОГЗОЛМАА

4823010004



Соёл, урлагийн газрын даргын
2023 оны 0 сарын 27-ны
өдрийн 09 тушаалын
хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИН НЭМЭГДЭЛ

№	Албан тушаал	Овог, нэр	Төрийн албанд ажилласан		Албан тушаалын зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдэл			
			жил	сар			Төрийн алба хаасан хугацааны (хувь)	Орон нутагт ажилласны (хувь)	Зэрэг, дэв (хувь)	Ажил хавсарсны нэмэгдэл, ЭБАТ
1	Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	С.Отгонбаямба	11.4	136	T3-8	853,375	11	20	Дэс, гутгаар 20	10
2	Хяналт шинжилгээ үнэлгээ, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн	Ё.Нэргүй	15.7	189	T3-9	791,532	15	20	-	40
3	Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн	С.Намжилмаа	12.2	146.4	T3-9	791,532	12	20	-	-
4	Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Б.Надмидцэрэн	0.9	10.8	T3-9	791,532	-	20	-	-
5	Нягтлан бодогч	Н.Энхмарт	12.2	146.4	TУ-8	861,490	12	-	-	-
6	Архивч, бичиг хэрэг, нярав	Б.Алимаа	1.7	19	TУ-5	686,638	-	-	-	-


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/02

Мандалговь

Нягтлан бодогч Н.Энхмартын цалинг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, 47 дугаар зүйлийн 47.1, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дүгээр тогтоолын 5, 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 05/645 албан бичгийн дагуу Намжилноров овогтой Энхмартыг 2023 оны 01 сарын 01 ны өдрөөс тус газрын нягтлан бодогчоор томилсугай.
2. Н.Энхмартын албан тушаалын цалинг ТҮ-8 зэрэглэлээр 861,490 (найман зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун ерэн) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 12 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЦОГЗОЛМАА

4823010006



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 1/03

Мандалговь

Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн С.Отгонбямбын
цалинг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Улсын Их 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.10 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дүгээр тогтоолын 2, 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2023 оны 05/645 албан бичгийн дагуу Сүхбаатар овогтой Отгонбямбыг 2023 оны 01 сарын 01 ны өдрөөс тус газрын Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр томилсугай.

2. С.Отгонбямбын албан тушаалын цалинг ТЗ-8 зэрэглэлээр 853,375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан таван) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 12 хувь, зэрэг дэвийн нэмэгдлийг 20 хувь, орон нутагт ажилласны нэмэгдлийг 20 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЦОГЗОЛМАА

4823010012



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/04

Мандалговь

Байгууллагын баримт бичиг нягтлан
шалгах комисс байгуулах тухай

Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 25.2.1, 25.2.2, 25.2.3, 25.2.4, 25.2.5 дахь заалт, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дүгээр тушаал “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын архивын баримт нягтлан шалгах комисс /БНШК/-ыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээ хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд: Нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга: - Архив бичиг хэргийн ажилтан

2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үйл ажиллагааг явуулахыг Баримт нягтлан шалгах комисст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЦОГЗОЛМАА



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/05

Мандалговь

Сургалтын зардал гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.4, дэх заалт Дундговь аймгийн засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн А/01 захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Соёлын төвийн дарга нарт зохион байгуулах “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах нь” арга зүйн сургалтын зардлыг хавсралтаар баталсугай.

2. Сургалтад зарцуулагдах 403,700 (дөрвөн зуун гурван мянга долоон зуу) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЦОГЗОЛМАА

4823010015